



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 335

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах ┐
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.3, 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 8 нэрийн, нийт 94,298,629.32 (ерэн дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга зургаан зуун хорин есөн төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Мэдээлэл холбооны сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

139005672
17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 26 дугаар сарын 26-ны өдрийн
 26 дугаар тогтоолын хавсралт

**"МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ СЭЛБЭГЭЭР АШИГЛАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2022 оны 498 дугаар тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)
1	ЗИЛ-130, 12-04 АРА	1993/1996	244996	10,854,000.00	10,854,000.00	-	5,500,000.00
2	Фургон /УАЗ-220692/, 74-37 БУА	2007/2007	221000	12,500,000.00	12,500,000.00	-	3,500,000.00
3	ЗИЛ-130, 10-17 ДУА	1995/1995	215320	7,796,790.00	7,796,790.00	-	5,500,000.00
4	Фургон /УАЗ-452/, 88-34 ХӨА	2007/2007	198000	10,272,727.27	10,272,727.27	-	3,500,000.00
5	Памакс /ачааны машин/, 02- 87 ДАХ	2001/2008	232000	14,688,816.81	14,688,816.81	-	3,500,000.00
6	УАЗ-3303, 95-44 УБУ	2000/2000	212125	7,055,100.00	7,055,100.00	-	3,500,000.00
7	Ниссан Прессаж, 53-33 ОРО	1998/1998	267631	9,277,147.44	9,277,147.44	-	3,500,000.00
8	Кантер, 78-34 УБП	1995/2009	256000	21,854,047.80	21,854,047.80	-	7,500,000.00
	Нийт үнэ			94,298,629.32 (ерэн дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга зургаан зуун хорин есөн төгрөг гучин хоёр мөнгө)	94,298,629.32 (ерэн дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга зургаан зуун хорин есөн төгрөг гучин хоёр мөнгө)		